

## **ГААЛИЙН АЛБАН ТАТВАРЫГ ХӨНГӨЛЖ, БУЦААН ОЛГОХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Гаалийн албан татварыг хөнгөлж, буцаан олгох тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын<sup>1</sup> /цаашид Аргачлал гэх/ 1.3-т заасан хүрээнд хамаарахгүй тул урьдчилан тандан судлах ажиллагааг Аргачлалын 2.1-т заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

### **НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ**

Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.70-д "Газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна" гэсэн зорилт дэвшүүлсэн болно. Энэхүү зорилтын хүрээнд Засгийн газрын 2017 оны 92 дугаар тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийг хэрэгжүүлэх үүрэг бүхий 100 хувь төрийн өмчит компани байгуулах шийдвэр гарч 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулсан.

Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг БНЭУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр барьж байгуулахаар шийдвэрлэсний дагуу үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн баталж, төслийн менежментийн зөвлөх компаниар Энэтхэгийн Инженерс Индиа компани ажиллаж эхлээд байна.

Төслийн дараагийн үе шат буюу зураг төслийн ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна.

Үйлдвэрийг байгуулах бэлтгэл ажлыг хангахын тулд Засгийн газраас шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлэн, үйлдвэрийн гаднах дэд бүтцийн ажлыг 2018 оны 2 дугаар сараас эхлүүлж, төмөр зам, авто зам болон цахилгаан дамжуулах агаарын шугам барьж байгуулах төслүүдийг энэ оны 9 дүгээр сард бүрэн дуусгахаар төлөвлөж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 129 дүгээр тогтоолын нэгдүгээр хэсэгт "Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн хүрээнд үйлдвэрийн ажилчдыг орон сууцаар хангах зорилгоор Дорноговь аймгийн Сайншанд хотын нутаг дэвсгэрт барих 550 айлын орон сууцны хотхоны бүтээн байгуулалтын ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна", хоёрдугаар хэсэгт "Хотхоны бүтээн байгуулалтад шаардагдах бараа материал, тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулж 2019 оны 05 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ" гэж тус тус заасан болно.

Үйлдвэрийн гаднах дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэхэд нийт төсөвт өртгөөс

---

<sup>1</sup>Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

35 орчим тэрбум төгрөгийн хэмнэлт гарсан бөгөөд энэхүү хэмнэсэн мөнгөн хөрөнгийг төслийн цаашдын хэрэгжилт болон ирээдүйд чиглэсэн хөрөнгө оруулалт хийх санаачлагыг Засгийн газраас дэмжин Хөгжлийн банканд нээсэн зээлийн шугамаас уг бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх шийдвэрийг гаргасан. Нэг талаас үйлчилгээний төв, орон сууцны цогцолборыг харьцангуй бага өртөг зардлаар барьж байгуулахаар төлөвлөж байгаа, нөгөө талаас өндөр хүүтэй Хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлэх учир үйлдвэрийн ажилчдын хотхоны бүтээн байгуулалтыг татварын бодлогоор дэмжих зайлшгүй шаардлага үүсэж байна.

Иймд асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, улмаар түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

### **1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал**

Тандан судалгааны ажил болон хуулийн төсөл боловсруулах хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний статистикийн хороо, Гаалийн ерөнхий газар болон газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэхээр төсөл хэрэгжүүлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудаас статистик тоон мэдээлэл цуглуулах, тодорхой тохиолдлыг судлах хэлбэрээр чанарын мэдээлэл цуглуулсан болно.

Гаалийн албан татварыг хөнгөлж, буцаан олгох тухай хуулийн төсөл нь Дорноговь аймгийн Сайншанд сумын нутаг дэвсгэрт барих байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх бөгөөд гагцхүү энэхүү хотхоны барилга байгууламжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй бараа материалд ногдуулсан гаалийн албан татварыг 100 хувь хөнгөлж, буцаан олгох харилцааг зохицуулахаар боловсруулсан.

Газрын тосны үйлдвэрийн ажилчдын хотхоны бүтээн байгуулалтын ажилд оролцох аж ахуйн нэгж, байгууллагуудад уг хууль үйлчлэх бөгөөд тэдгээрт ногдуулсан татварыг дараа жилд нь буцаан олгох буюу 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл мөрдөгдөхөөр зохицуулсан болно.

Үйлдвэрийн ажилчдын хотхон байгуулагдсанаар Дорноговь аймгийн Сайншанд, Алтанширээ зэрэг сумдын нийгэм-эдийн засгийн хөгжил эрчимжиж, шинээр байнгын ажлын байр бий болох бөгөөд нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгжийн хууль ёсны ашиг, сонирхолд сөрөг үр нөлөө үзүүлэхгүй болно.

### **1.2. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл**

Монгол улсын хөгжлийн стратегийн хүрээнд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эрчим хүчний эх үүсвэрийн импортын хамаарлаас гаргах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч орон болох Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг биелүүлэх стратегийн ач холбогдол бүхий төслийг хэрэгжүүлэх, үйлдвэрийн барилга-угсралтын ажил гүйцэтгэх үед буюу ирэх 4-5 жилийн хугацаанд орон нутагт ажиллах гадаад,

дотоодын олон тооны ажиллагсад, гэрээлэгчдийг ажиллаж, амьдрах нөхцөлөөр хангах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын банк хоорондын Зээлийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг хэрэгжүүлэхэд Дорноговь аймгийн Сайншанд хотын нутаг дэвсгэрт газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн бүтээн байгуулалтад оролцох дотоод, гадаадын туслан гүйцэтгэгч, гэрээлэгч нарын ажилчдыг ажиллаж, амьдрах таатай нөхцөлөөр хангах үүргийг монголын тал хүлээсэн.

Үйлдвэрийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлын оргил жилүүдэд давхардсан тоогоор орон нутагт гадаад дотоодын инженер-техникийн болон туслах 7000 гаруй ажилтан ажиллах бөгөөд үйлдвэр ашиглалтад орсон цагаас эхлэн 560 гаруй инженер, техникийн ажилчид орон нутагт ажиллаж амьдрах тул үйлдвэрийн ажилчдын хотхоныг богино хугацаанд хямд өртгөөр барихад энэхүү хуулийн төслийн зорилго оршино. Мөн үйлдвэр ашиглалтад орсон цагаас эхлэн 560 гаруй инженер, техникийн ажилчид байнгын оршин сууж ажиллах тооцоолол гарсан.

Төсөл хэрэгжүүлэхэд оролцогч, гэрээлэгч, туслан гүйцэтгэгч тус бүр өөрийн байрлах түр бааз байгуулан ажиллуулах боломжтой ч энэ нь өртөг зардал өндөр, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх үр дагавартай байна. Олон улсын туршлагаас авч үзэхэд түр байрлах баазад хоногт нэг хүнд ногдох зардлын хэмжээ 25-35 ам.доллар байдаг байна. Үүнээс тооцоолоход үйлдвэрийн барилга-угсралтын ажлын оргил жилд давхардсан тоогоор 8000 орчим ажилтан ажиллах бөгөөд эдгээр ажилчид түр баазад байрлан үйлчилгээ авахад нийт 140,4-196,6 орчим тэрбум төгрөгийн зардал гарахаар байна.

Иймээс үргүй зардлыг хэмнэж, үйлдвэрийг байгуулах үед инженер, техникийн болон туслах ажилчдыг ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ үйлдвэрийн ирээдүйн ажилчдыг орон сууцаар хангах, нийгмийн асуудлыг цогцод нь шийдвэрлэх зорилгоор газрын тос боловсруулах үйлдвэрийг түшиглэн 550 айлын орон сууц бүхий хотхон байгуулах саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, хотхоны бүтээн байгуулалтын ажлыг 2019 оны эхний хагас жилд эхлүүлэх үүргийг Батлан хамгаалахын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад тус тус даалгасан байна.

Үйлдвэрийн гаднах дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэхэд нийт төсөвт өртгөөс 35 орчим тэрбум төгрөгийн хэмнэлт гарсан бөгөөд энэхүү хэмнэсэн мөнгөн хөрөнгийг төслийн цаашдын хэрэгжилт болон ирээдүйд чиглэсэн хөрөнгө оруулалт хийх санаачлагыг Засгийн газраас дэмжин Хөгжлийн банканд нээсэн зээлийн шугамаас уг бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх шийдвэрийг гаргасан. Нэг талаас үйлчилгээний төв, орон сууцны цогцолборыг харьцангуй бага өртөг зардлаар барьж байгуулахаар төлөвлөж байгаа боловч нөгөө талаас өндөр хүүтэй Хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээр энэхүү хотхоны бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэх тул зардлыг хэмнэх үүднээс татварын бодлогоор дэмжих зайлшгүй шаардлага үүсэж байна.

Энэхүү хуулийг баталснаар хотхоны төслийн хөрөнгө оруулалтын зардлыг 5 хүртэл хувиар бууруулах боломжтой бөгөөд газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөлд төрөөс үзүүлж байгаа бодит дэмжлэг болох юм.

### ХОЁР.АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Энэ хуулийн төслийг баталснаар газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын орон сууц, оффис үйлчилгээний цогцолборын бүтээн байгуулалтад шаардагдлагатай бараа материалд төлсөн гаалийн албан татварыг хөнгөлж, буцаан олгох хууль, эрх зүйн орчин бүрдэнэ.

Үйлдвэрийн ажилчдын орон сууцны хотхон барихад шаардлагатай импортоор оруулж ирэх бараа материалыг гаалийн албан татвараас чөлөөлснөөр газрын тос боловсруулах үйлдвэрийн нийт төсөвт өртөг багасах, эхний хөрөнгө оруулалтын зардлыг бууруулах, улмаар дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжихэд ач холбогдолтой юм. Түүнчлэн Хөгжлийн банкны өндөр хүүтэй зээлийн эх үүсвэрээр санхүүжигдэж буй төрийн өмчит үйлдвэрийн газрын зээлийн хүүгийн дарамтыг бууруулна.

### ГУРАВ.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРЫН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Зохицуулалтын хувилбаруудын эерэг, сөрөг талыг харьцуулсан байдал (Хүснэгт 1)

№	Зохицуулалтын хувилбар	Харьцуулалт		Үр дүн
		Эерэг	Сөрөг	
1	"Тэг" хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах;		Шинэ бүтээн байгуулалтын ажлын өртөг нэмэгдэнэ.	Сөрөг үр дүнтэй.
2	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;	Гаалийн албан татварыг хөнгөлж, буцаан олгох нь санхүүгийн дарамтаас чөлөөлөхөд чиглэгдсэн тул соён гэгээрүүлэх ажил шаардлагагүй.	Сөрөг үр дагаваргүй.	Үр дүн багатай.
3	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;	Гаалийн албан татварыг хөнгөлж, буцаан олгох асуудалд төрийн дэмжлэг шаардлагатай.	Сөрөг үр дагаваргүй.	Үр дүн өндөр.
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх;	Шаардлагагүй.	Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаа энэ үед санхүүжилт байхгүй.	Үр дүн багатай.
5	Төрийн бус байгууллага,	Шаардлагагүй.	Гаалийн албан татварыг хөнгөлж,	Үр дүнгүй.

	хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;		буцаан олгох асуудалд төрийн бус байгууллага оролцох боломжгүй.	
6	Захиргааны шийдвэр гаргах;	Шаардлагагүй.	Эрх олгосон заалт байхгүй учраас Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.3-т заасан шийдвэр гаргаж, зохицуулах боломжгүй.	Үр дүнгүй.
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах;	Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт "татварыг зөвхөн Улсын Их Хурал" хуулиар бий болгох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй." гэж заасан тул Гаалийн албан татварыг хөнгөлж, буцаан олгох тухай "хууль тогтоомжийн төсөл боловсруулах" шаардлагатай байна.		Үр дүнтэй гэж үзэж байна.

Асуудлыг шийдвэрлэх хувилбаруудын зорилгод хүрэх байдал болон тэдгээрийн эерэг, сөрөг талаас нь үнэлэхэд хувилбар 7 нь тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх хамгийн үр дүнтэйгээр шийдвэрлэж чадах хувилбар болох нь тандан судалгаагаар тогтоогдож байна.

Гаалийн албан татварыг хөнгөлж, буцаан олгох тухай асуудлыг хуулиар шийдвэрлэхээр холбогдох хуульд заасан тул цаашид хувилбар 7 буюу "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах" гэсэн зохицуулалтын хувилбар болгон үргэлжлүүлэн судлах нь зүйтэй гэж үзлээ.

#### **ДӨРӨВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАНУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Аргачлалын 6-д заасны дагуу үр нөлөөг ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

*Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.*

##### **4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө**

Тус хууль нь хүний эрхийн зөрчил, хүний эрхийг хязгаарласан мөн жөндөрийн тэгш байдлыг зөрчих зохицуулалт агуулаагүй, тэгш хандлагатай. Жөндөр харгалзахгүй ажлын байр нэмэгдэнэ.

## 4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Манай улс газрын тосны бүтээгдэхүүнийхээ хэрэглээг 100% импортоор хангадаг бөгөөд 2017 онд 1.49 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсноос 94.5 хувийг ОХУ-аас, 3.4 хувийг БНСУ-аас, 1.8 хувийг БНХАУ-аас, үлдсэн 0.3 хувийг бусад улсуудаас тус тус импортолжээ. Газрын тосны бүтээгдэхүүнийг төрлөөр нь авч үзвэл 90-ээс дээш октантай автобензин 27 хувь, 90-ээс доош октантай автобензин 4 хувь, дизель түлш 50 хувь, онгоцны түлш 2 хувь, тос тосолгооны материал, мазут, хий гэх мэт бусад бүтээгдэхүүн 16 хувийг тус тус эзэлж байна.

График 1. Газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ (нэгж: мян.тонн)



Эх сурвалж: АМГТГ

Дотоодын түүхий эдэд түшиглэн байгуулагдах үйлдвэрүүдийн хувьд Монгол Улсыг газрын тосны бүтээгдэхүүнээр хангаж, нефть-химийн технологийн аж үйлдвэрийн суурийг бий болгох бөгөөд ЕВРО-4,5 стандартын шаардлага хангасан автобензин, дизель түлш, онгоцны түлш, шингэрүүлсэн шатдаг хий болон бусад дагалдах бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд оршино.

Хуулийн төсөл батлагдсанаар газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын орон сууц, оффис үйлчилгээний цогцолборын бүтээн байгуулалтад шаардагдлагатай бараа материалыг гаалийн албан татвараас хөнгөлж, буцаан олгох эрх зүйн зохицуулалт бүрдэнэ. Гаалийн албан татварыг хөнгөлж, буцаан олгосноор газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын орон сууцны хотхоны нийт төсөвт өртөг багасах улмаар газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн хөрөнгө оруулалтын зардлыг багасгах үр ашигтай юм.

## 4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Энэхүү хууль батлагдсанаар газрын тосны бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэснээр нийгэмд дараах эерэг өөрчлөлтүүд гарна. Үүнд:

- Үйлдвэрийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажилд оролцох болон үйлдвэр ажилчдын ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

#### **4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө**

Хүрээлэн буй орчинд нөлөөлж байгалийн унаган төрхийг эвдэж доройтуулах, ус, хөрс, агаарыг бохирдуулах үйлчлэл үзүүлэх магадлал байхгүй байна.

#### **4.5.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх**

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” баримт бичгийн Зорилт 3-д “... гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангана” гэж, Их Хурлын 2015 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ын 4.1.5-д “дэвшилтэт техник, технологи, өндөр технологи, инновацид суурилсан, эдийн засаг, нийгмийн үр ашиг бүхий боловсруулах, дахин боловсруулах, бүтээлч аж үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн бодлогоор дэмжих” гэж, Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.13 дахь хэсэгт “Дотоодын үйлдвэрлэлийг гааль, татварын бодлогоор дэмжих” гэж, 2.70-д “... газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна” гэж, Засгийн газрын 2018 оны 169 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого (2018-2027)”-ын 2.3.2.2 “газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг татварын таатай бодлогоор дэмжих” гэж тус тус заасантай нийцэж байна.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хуультай нийцсэн бөгөөд бусад хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагагүй юм.

#### **ТАВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ**

Аргачлалын 7-д зааснаар хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг

-Зорилгод хүрэх байдал;

-Зардал, үр өгөөжийн харьцаа;

-Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;

-Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;

-Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Гаалийн татвараас хөнгөлж, буцаан олгох асуудлыг хуулиар шийдвэрлэхээр холбогдох хуульд заасан тул цаашид хувилбар 7 буюу “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах” гэсэн зохицуулалтын хувилбар болгон үргэлжлүүлэн судлах нь зүйтэй гэж үзлээ.

“Хууль тогтоомжийн төсөл боловсруулах” гэсэн зохицуулалтын хувилбар нь дэвшүүлсэн зорилгод бүрэн хүрэх боломжтой ба энэ нь Монгол Улсын Үндсэн хууль

болон хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээний агуулга, зарчимд нийцнэ гэж дүгнэж байна.

## **ЗУРГАА.ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Азийн улс орнууд болох Вьетнам, Индонез, Малайз, Бангладеш зэрэг орны татварын орчны жишээн дээр судалж үзэхэд дотооддоо ихээхэн хөрөнгө оруулалт шаардах, улс орны стратегийн чухал салбарт хийгдэх бүтээн байгуулалтын ажилд төрөөс татварын бодлогоор дамжуулан нийтлэг байдлаар орлогын албан татвар, гаалийн албан татвар, үл хөдлөх хөрөнгийн төлбөрөөс урт хугацаанд чөлөөлөх, үл хөдлөх эд хөрөнгийн элэгдэл хорогдлын хугацааг түргэвчилсэн байдлаар элэгдүүлэх, алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох замаар хөрөнгө оруулалтын таатай нөхцөлийг төрийн бодлогоор бүрдүүлж өгдөг байна.

### **ДОЛОО.ЗӨВЛӨМЖ**

Тандан судалгааны өмнөх шатанд дэвшүүлсэн зорилгод хүрэхийн тулд хувилбар 7 буюу "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах" гэсэн зохицуулалтын хувилбарыг сонгох нь зүйтэй гэж үзлээ.

Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт "татварыг зөвхөн Улсын Их Хурал хуулиар бий болгох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй." гэж заасан тул гаалийн албан татвараас чөлөөлөх тухай "хууль тогтоомжийн төсөл боловсруулах" шаардлагатай болно.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах зохицуулалтын хувилбар нь одоогийн нөхцөлд дэвшүүлсэн зорилгыг хангах хамгийн боломжит хувилбар бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө нь байж болох хэмжээнээс хэтрэхгүй болно.

Энэ хууль батлагдсанаар газрын тосны үйлдвэрийн ажилчдын орон сууцны хотхоны бүтээн байгуулалтад шаардагдах гадаадаас худалдан авах бараа материалын гаалийн албан татварыг хөнгөлөх, буцаан олгоход хуулийн төслийн зорилго оршино. Тус хотхон нь газрын тос боловсруулах үйлдвэрийн барилга-угсралтын үед Сайншанд хотод удаан хугацаагаар ажиллах гадаад, дотоодын мэргэжилтнүүдийг ажиллаж, амьдрах нөхцөлөөр хангах, улмаар ирээдүйд үйлдвэрт ажиллах мэргэжилтнүүдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилготой юм.

### **ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ**

(Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох	Тийм	Үгүй	Энэ чиглэлээр хуулийн төсөлд шинээр заалт

нийцэж буй эсэх	эсэх			тусгагдахгүй.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Аль нэг бүлэгт давуу байдал үүсгээгүй.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Бүрэн нийцэж байна.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Аж ахуйн нэгжүүдэд нөлөө үзүүлнэ.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Хуульд ийм зохицуулалт тусгаагүй.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн	Тийм	Үгүй	Шударга, тэгш эрх, үр өгөөжтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн.

	зөвлөмжид нийцэж байгаа эсэх			
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Хуульд ийм зохицуулалт тусгаагүй.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдаагүй.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Үйл ажиллагаанд оролцогч аж ахуйн нэгжүүд.
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Үгүй
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Үгүй
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Үйл ажиллагаанд оролцогчдод бүгдэд нь боломж олгоно.
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	-
4. Жендэрийн	5.1. Жендэрийн үзэл	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.

эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	баримтлалыг тусгасан эсэх			
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.

## ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Шинэ техник, технологийг нэвтрүүлэх, нутагшуулах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татаж, үйлдвэрлэлийн бүтцийг сайжруулах зорилготой.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Үйлдвэрлэл, технологийн паркийг бүрэн утгаар нь байгуулж хөгжүүлснээр импортын хараат байдлын нөлөөллөөс сэргийлж чадна.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	бий болгох эсэх			
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Удирдлага компанийн санхүүжилтийн эх үүсвэр олох асуудлыг тодорхой болгосон.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Нэмэлт зардал гарахгүй, зардлыг бууруулна.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх			
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Шаардлага тавигдана.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Үйлдвэрлэл, технологийн паркууд байгуулагдаж, ажлын байр бий болно.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ. Хүнд болон хөнгөн үйлдвэрийг дагаж жижиг дунд үйлдвэрүүд хөгжинэ.
9.Төрийн захиргааны	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Одоо байгаа бүтэц өөрчлөгдөхгүй.

байгууллага	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдал нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Хөрөнгө оруулалтын орчин сайжирч, эерэг нөлөө үзүүлнэ.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

### НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Үйлдвэрийн салбар хөгжиж, ажлын байр олноор бий болно.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Тодорхой үйл ажиллагаа эрхлэгчдэд нөлөө үзүүлнэ.

	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдал нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Шаардлагатай тохиолдолд стандарт боловсруулж, батлах.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, ажиллагаанд нөлөөлөх эсэх үйл	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.

	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Үйлдвэрүүд мэргэжлийн ажилчид бэлтгэх, шинээр өөр газраас ажилчид элсүүлэх зэрэг процесс явагдана.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох,	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх			
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

### БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
-------------------	---------------------	---------	---------

1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Агаарын бохирдлыг бууруулахад нөлөөлнө.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эрчим хүчний хэрэглээ нэмэгдэнэ.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эрчим хүчний шинэ эх үүсвэрийг болгоно.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Агаарын бохирдлыг бууруулахад нөлөөлнө.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Усны хэрэглээ нэмэгдэнэ.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Холбогдох стандартыг мөрдөнө.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Холбогдох стандартыг мөрдөнө.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх	Тийм	Үгүй	Холбогдох стандартыг мөрдөнө.

	эсэх			
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Үйлдвэрлэлийн зориулалттай газарт үйл ажиллагаа явуулна.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Үйлдвэрлэлийн зориулалттай газарт үйл ажиллагаа явуулна.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Холбогдох стандартыг мөрдөнө.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

Гадаадын хөрөнгө оруулалтыг татах хүрээнд зарим улс орнууд гаалийн татвар, ашиг орлогын албан татвар, НӨАТ зэрэгт олгосон урамшуулал, хөнгөлөлтүүдийн харьцуулсан жагсаалт

Улсын нэр	Урамшууллын бодлого
Тайланд	<ul style="list-style-type: none"> <li>- Тоног төхөөрөмжийн гаалийн татварыг 50-100 хувь чөлөөлөх:</li> <li>- 3 жил татвараас чөлөөлж, 5 жилээр сунгах</li> <li>- Экспортод зориулан ашиглах түүхий эд, материалын импортын гаалийн татварыг 1-5 жил чөлөөлж, хугацааг сунгана</li> <li>- Ашиг орлогын татвараас 8 жил чөлөөлөх,</li> <li>- Байршлаас хамаарч 5 жил 50 хувь, тээвэр, цахилгаан, усны зардлыг 2 дахин өсгөвөл 10 жил хөнгөлөх, цэвэр ашгаас элэгдэл хорогдлыг тооцох</li> </ul>
Индонез	<ul style="list-style-type: none"> <li>- Үйлдвэрийн тоног төхөөрөмж, түүхий эдийн импортын татвар, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө</li> <li>- Стратегийн зориулалттай үйлдвэрийн татварыг бууруулах, төрөл бүрийн татвараас чөлөөлөх, элэгдэл хорогдлын шимтгэлийн хугацааг багасгах</li> </ul>
Вьетнам	<ul style="list-style-type: none"> <li>- Дэд бүтцийн компанийн татварыг 10 хувь бууруулж, 4 жил татвараас чөлөөлж, 9 жил бууруулна.</li> <li>- Шинэ компанийн татварыг 20 хувь бууруулна, 2 жил татвараас чөлөөлж, 4 жил татварыг бууруулна.</li> </ul>
Малайз	<ul style="list-style-type: none"> <li>- Хуулийн этгээдийн үр ашгийн албан татварыг 28 хувиас 9 хувь бууруулах</li> <li>- Түүхий эд, тоног төхөөрөмжийг импортын татвараас чөлөөлөх</li> </ul>
Мьянмар	<ul style="list-style-type: none"> <li>- 5 жил орлогын татвараас чөлөөлнө, хугацааг сунгах</li> <li>- Дахин хөрөнгө оруулалт хийвэл татварыг хөнгөлөх</li> <li>- Экспортод бүтээгдэхүүн гаргавал 50 хүртэл хувийг ашгаас нь хөнгөлөх, худалдааны татварыг хөнгөлнө</li> <li>- Судалгааны ажлын зардлыг гаалийн орлогын татвараас бүрэн чөлөөлнө</li> <li>- Түүхий эд, материалын зардлыг импортын болон бусад татвараас чөлөөлөх</li> </ul>
Энэтхэг	<ul style="list-style-type: none"> <li>- Эхний 5 жилд татвараас 100 хувь, дараагийн 5 жилд 50 хувь, нийтдээ 15 жил татвараас хөнгөлнө.</li> <li>- Дэд бүтэц, эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, дахин боловсруулах үйлдвэр, судалгааны ажилд төрөл бүрийн хөнгөлөлт үзүүлэх</li> <li>- Чөлөөт бүсүүдэд татварын хөнгөлөлт үзүүлнэ.</li> </ul>
Мексик	<ul style="list-style-type: none"> <li>- Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт үзүүлнэ.</li> <li>- Мексикт байдаг үйлдвэрлэгч нар шаардлагатай эд анги, түүхий эд, төхөөрөмж зэргийг 0, 3, 5%-ийн татварын хөнгөлөлттэй импортолж болно.</li> </ul>
Турк	<ul style="list-style-type: none"> <li>- Газар эзэмшигчийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө.</li> <li>- Барилга, байгууламж барьсны дараа 5 жил үндсэн хөрөнгийн татвараас чөлөөлнө</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>- Ус, хий, холбооны төлбөрийг татвараас чөлөөлнө</li> </ul>
Саудын Араб	<ul style="list-style-type: none"> <li>- Хуулийн этгээдийн орлогын албан татварыг 20 хувь</li> <li>- Үндсэн хөрөнгө, түүхий эд, материалыг импортлох татварыг чөлөөлнө</li> <li>- Бага хүүтэй зээл олгох</li> </ul>
ӨАБНУ	<ul style="list-style-type: none"> <li>- Аж үйлдвэрийн салбарын тусгай бүсэд гаалийн татвар, НӨАТ, импортын татвараас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх</li> <li>- Машин үйлдвэрлэлийн салбарыг импортын гаалийн татвараас чөлөөлөх</li> <li>- Зээлийн хөрөнгө оруулалтын 20 хувьтай тэнцэх тэтгэлэг олгоно</li> <li>- Нэхмэл, хувцас эдлэлийг импортын татвараас чөлөөлнө, хөнгөлөлттэй зээл олгоно</li> <li>- Үйлдвэржилтийн инновацийг дэмжих хөтөлбөрт дэмжлэг үзүүлдэг</li> </ul>
Египет	<ul style="list-style-type: none"> <li>- Дотоод хөрөнгө оруулалтад газар эзэмшсэний татварыг 10 хувь чөлөөлөх</li> <li>- Хөрөнгө оруулалтын бүсэд гаалийн татвар, борлуулалтын татварыг 5-10 жилийн татварыг барагдуулна.</li> <li>- Экспортыг барааг татвараас чөлөөлнө</li> <li>- Эзэмшлийн татварыг 10 хувь, цалингийн татварыг 5 хувь хөнгөлнө.</li> <li>- Ажлын байр бага үнэтэй түрээслэх ба түрээслүүлэх</li> </ul>
ОХУ	<ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын ашгийн татварыг багасгах, эд хөрөнгийн татвар, газрын татвараас чөлөөлөх, экспорт, импортын татварыг НӨАТ-аас чөлөөлнө</li> </ul>
Польш	<ul style="list-style-type: none"> <li>- Гаалийн татварыг 19 хувь хөнгөлөх, чөлөөлөх</li> <li>Шинэ ажилтнуудын цалингаас авах орлогын албан татварыг 2 жилийн хугацаанд:</li> <li>- Томоохон хэмжээний байгууллагад 30-50 хувь</li> <li>- Дунд хэмжээний байгууллагад 40-60 хувь</li> <li>- Жижиг хэмжээний байгууллагад бол 50-70 хувь</li> <li>- Үндсэн хөрөнгийн татвараас чөлөөлөх, хөнгөлөх</li> </ul>

**ГААЛИЙН АЛБАН ТАТВАРЫГ ХӨНГӨЛЖ, БУЦААН ОЛГОХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ ҮНЭЛЭХ  
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Энэхүү үнэлгээг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас боловсруулсан 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан Гаалийн албан татварыг хөнгөлж, буцаан олгох тухай хуулийн төслийн зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>1</sup> 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь “Анхдагч” хуулийн төсөл<sup>2</sup> хэлбэрээр боловсруулагдсан байна.

Гаалийн албан татварыг хөнгөлж, буцаан олгох тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”<sup>3</sup>-д /цаашид Аргачлал гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх;

**ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ  
СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д<sup>4</sup> заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Ойлгомжтой байдал;
3. Харилцан уялдаа зэрэг болно.

---

<sup>1</sup>[www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)

<sup>2</sup>“Хууль санаачлагч нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай, эсхүл тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулна” Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дүгээр зүйлийн 23.1 дэх хэсэг.

<sup>3</sup>Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт.

<sup>4</sup>Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 2.9 "... хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болно".

### **Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:**

#### **Зорилгод хүрэх байдал:**

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухайн хуулийн төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох билээ. Иймд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

#### **Ойлгомжтой байдал:**

Хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг. Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд<sup>5</sup> заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

#### **Харилцан уялдаа:**

Хуулийн төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомж болон төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдын чиг үүрэг давхардал, зөрчилдөөнгүй байх шаардлагатай. Иймд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заан агуулгын шаардлагыг<sup>6</sup> хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгож байна.

**“Хүлээн зөвшөөрөгдөх байдал, практикт хэрэглэх боломж болон зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй тухай:**

Энэхүү шалгуур үзүүлэлтээр тухайн хуулийн төслийн зохицуулалтыг иргэд, байгууллага хэрхэн хүлээн авах, тэдгээрт шинээр үүрэг хүлээлгэсэн эсэхийг шалгадаг. Тус хуулийн төслөөр иргэд, аж ахуйн нэгжид шинээр ямар нэгэн чиг үүргийг нэмж хүлээлгэхгүй, иргэдийн хувьд эерэг үр нөлөөтэй тул **“хүлээн зөвшөөрөгдөх байдал”** шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

**“Практикт хэрэгжих боломж”** шалгуур үзүүлэлтээр тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэх, хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, санхүү болон хүний нөөцийн байдал зэргийг тогтоодог. Өмнө нь энэ

<sup>1</sup>Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

<sup>2</sup>Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл.

төрлийн хууль газрын тосны салбарт хэрэгжиж байсан туршлага бий бөгөөд түүний алдаа, сургамжид үндэслэн илүү нарийвчлан зохицуулахаар хуулийн төсөлд тусгагдсан байна.

Мөн дээрх үндэслэлээс гадна тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийх тул цаг хугацаа, нөөцийн хэмнэлт хийх үүднээс “практикт хэрэгжих боломж” болон “зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

### ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо:

Хүснэгт 1

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30, 32 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах
3	Харилцан уялдаа	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг шалгах

#### 1. Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Гаалийн албан татварыг хөнгөлж, буцаан олгох тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн хуулийн төслийн зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорьлоо.

Энэ дагуу Гаалийн албан татварыг хөнгөлж, буцаан олгох тухай хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зохицуулалтыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийнэ.

Хуулийн төслийн тандан судалгаа, үзэл баримтлал, хуулийн төслийн бүтэц, зохицуулах зүйлийн хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл “Татварын зохистой бодлогод тулгуурлан Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт барих газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын орон сууц, оффис үйлчилгээний цогцолборыг богино хугацаанд хямд өртгөөр барих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх” үндсэн зорилготой гэж үзэхээр байна.

Энэ зорилгын хүрээнд Гаалийн албан татварыг хөнгөлж, буцаан олгох тухай хуулийн төслийг боловсруулах хувилбарыг сонгожээ.

Иймд хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилгыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үзвэл:

- Гаалийн албан татварыг хөнгөлж, буцаан олгох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын хотхоны барилга байгууламжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй бараа материалд тухайн татварын жилд ногдуулан төлсөн гаалийн албан татварыг 100 хувь хөнгөлж, буцаан олгохоор тусгасан бөгөөд татварын буцаан олголтыг дараа жилийн эхний улиралд төлөхөөр зохицуулсан байна.

Дээрх зохицуулалтаас үзэхэд хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын хотхоныг богино хугацаанд хямд өртгөөр барих зорилгыг хангах зохицуулалтыг бүрэн тусгасан гэж үзэж болохоор байна.

## **2. Ойлгомжтой эсэх:**

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Гаалийн албан татварыг хөнгөлж, буцаан олгох тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд тавигдсан шаардлагыг хангасан эсэх асуудлын хүрээнд авч үзлээ.

Энэхүү хуулийн төслийн боловсруулалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ.

Гаалийн албан татварыг хөнгөлж, буцаан олгох тухай хуулийн төсөл нь 3 зүйлтэй, бөгөөд тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай, эсхүл тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагын үндсэн дээр боловсруулжээ.

Хуулийн төсөл нь хуулийн төслийн бүтэц, эх бичвэрийн агуулгад тавигдах шаардлагыг бүрэн хангасан байна.

Мөн бие даасан санаа бүрийг тусгай зүйлд тусгаж, заалт нь нэг өгүүлбэрээр илэрхийлэгдсэн, мөн хуулийн 30 дугаар зүйлд заасан хэл зүй, найруулгын нийтлэг шаардлагад нийцсэн байна.

### 3. Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурын дагуу үнэллээ:

*Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:*

Хүснэгт 2

Д/д	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Үндсэн хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан зарчмыг хангахад чиглэсэн байна.
2	29.1.5.Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зөрчилдөөгүй байна гэж үзэж болохоор байна.
3	29.1.10.Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байна.	Тус хуулийн төслийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулах, өөрчлөлт оруулах хуулийн төсөл байхгүй тусдаа үзэл баримтлалтай бөгөөд хуулийн төслийн хувьд зөрчилдөөнтэй асуудлууд байхгүй байна.

Аргачлалын 4.10-т заасан шалгуурыг хангасан эсэх:

Хүснэгт 3

Д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь Гаалийн тариф, гаалийн татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуультай зөрчилгүй байна.
2	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй	Хуулийн төслийн зорилгод хүрэх зохицуулалтыг сонгосон тул ямар нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагагүй.
3	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	-	Хуулийн төсөлд иргэдийн эрхийг хязгаарласан ямар нэгэн нэмэлт зохицуулалт тусгагдаагүй, харин аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих зохицуулалт тусгагдсан.
4	Хуулийн төслийн зүйл, заалт жөндөрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;		Ямар нэг зохицуулалтыг тусгах шаардлагагүй.
5	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	-	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Өрсөлдөөний тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
6	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Тийм	Хуулийн зохих заалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулиар зохицуулсан тул уг хуулийн төсөлд тухайлан тусгах шаардлагагүй юм.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон бусад хуулийн холбогдох зохицуулалттай зөрчилдсөн, иргэний эрхийг зөрчсөн, хязгаарласан, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгэсэн агуулга тусгагдаагүй байна.

## **ДӨРӨВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ**

Энэхүү үр нөлөө тооцох үнэлгээг Гаалийн албан татварыг хөнгөлж, буцаан олгох тухай хуулийн төсөл болон түүний үзэл баримтлалд тулгуурлан хийлээ.

Хуулийн төсөл нь дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хуулийн төслийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэх гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах **Дүгнэлтийг** хийж, **Зөвлөмж** боловсрууллаа:

### **Дүгнэлт:**

**Зорилгод хүрэх байдал:** Гаалийн албан татварыг хөнгөлж, буцаан олгох тухай хуулийн төслийн зохицуулалт нь төслийн үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг хангах боломжтой. Иймд зохицуулалтыг илүү нарийвчлах, хэрэгжих боломжийг нь нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг нэмж тусгах шаардлагагүй гэж үзлээ.

**Ойлгомжтой байдал:** Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хэлбэр, агуулгын хувьд хангасан байна.

**Харилцан уялдааг хангасан байдал:** Хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон холбогдох хуулийн зохицуулалттай зөрчилдсөн, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгэхээргүй байна.

### **Зөвлөмж:**

Хуулийн төслийн үнэлгээний дүгнэлтэд тулгуурлан хуулийн төслийн зохицуулалтыг хасах, нэмэх, өөрчлөх, тодруулах шаардлагагүй гэж үзлээ.

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ  
ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ГАРАХ  
ЗАРДЛЫН ТООЦОО**

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын гаргаж байгаа зардлыг тооцож, цаашид ачааллыг багасгах санал боловсруулахад энэхүү судалгааны зорилго оршино.

**1. Хуулийн этгээдийн зардал**

Энэхүү хууль нь Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт баригдах газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын хотхоны барилга байгууламжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй, импортоор оруулж ирэх бараа материалыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэхэд хамааралтай ба хуулийн этгээдийн хувьд хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гарах мөнгөн зардлыг тооцов.

Бараа материал импортлогч хуулийн этгээдийн хувьд нэгж бүрийн гаалийн бүрдүүлэлт хийх хугацаа нь дунджаар 480 минут байдаг бол нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлснөөр бүрдүүлэлт хийх хугацаа 120 минут болж нэгж бүрийн бүрдүүлэлт хийх хугацаа даруй 2 дахин буурах боломжтой юм.

<i>Хуулийн төслийн 1,2 дугаар зүйлтэй холбоотой хуулийн этгээдээс гарах зардал</i>	
<i>Гүйцэтгэх ажил, үйлчилгээ</i>	<i>Хэмжих нэгж</i>
Энэхүү хуультай танилцах, судлах	15 минут
Шинэ хуулийн мэдээлэл цуглуулах	15 минут
Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх	10 минут
Тооцоо хийх, нягтлах	120 минут
Олшруулах, архивлах	15 минут
Дотоод хуралдаан	60 минут
Шилжүүлэг хийх	30 минут
Нэмж мэдээлэл цуглуулах	30 минут
<b>Нийт</b>	<b>295 минут</b>
Уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын сарын дундаж цалин	1088.2 мян.төгрөг
Уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын минутын дундаж цалин	108 төгрөг
Ажлын хөлс	31840 төгрөг
Хамрагдагчдын тоо	10
Тоон үзүүлэлт	1
Давтамж	Байхгүй
<b>Нийт зардал</b>	<b>318400 төгрөг</b>

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Энэхүү хууль хэрэгжсэнээр хуулийн этгээдэд ачаалал бага гарах ба үүсэх нийт зардал 318400 төгрөг байна.

## 2. Төрийн байгууллагын зардал

<i>Хуулийн төслийн 1,2 дугаар зүйлтэй холбоотой Төрийн байгууллагаас гарах зардал</i>			
<i>Төрийн байгууллагууд</i>	<i>Гүйцэтгэх ажил, үйлчилгээ</i>	<i>Хэмжих нэгж</i>	
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Хуулийн төсөлд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийн саналыг авч Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдаас санал авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлнэ.	Мэдээлэл цуглуулах	2400 минут /ажлын 5 өдөр/
		Судалгаа, тооцоо хийх	1440 минут /ажлын 3 өдөр/
		Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулах	480 минут /ажлын 1 өдөр/
		Албан бичиг боловсруулах	20 минут
		Бичиг баримт олшруулах	15 минут
		Бичиг тараах, бүртгэх	60 минут
		Дотоод хуралдаан	60 минут
Гаалийн ерөнхий газар	“Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-ийн тухай олон улсын конвенцийн дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас ирүүлсэн гаалийн албан татвараас чөлөөлүүлэх технологийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл болон тусгай зориулалтын барилгын материалын шинж чанар, зориулалт, зүйл бүлгээр судлан тодорхойлох.		4800 минут /ажлын 10 өдөр/
<b>Нийт</b>		<b>9275 минут</b>	
Төрийн албан хаагчийн сарын дундаж цалин		717,100 төгрөг	
Төрийн албан хаагчийн минутын дундаж цалин		71 төгрөг	
Ажлын хөлс		658,525 төгрөг	
Хамрагдагчдын тоо		5	
Тоон үзүүлэлт		1	
Давтамж		Байхгүй	
<b>Нийт зардал</b>		<b>3,292,625 төгрөг</b>	

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, Гаалийн ерөнхий газар

Хууль батлагдсанаар Төрийн байгууллагаас зарцуулах хугацаа буюу ачаалал 9275 минут байх бөгөөд түүнтэй холбогдон гарах зардал нь 3,292,625 төгрөг байна.

### **Дүгнэлт**

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах зардлын тооцоог батлагдсан аргачлалын дагуу хийхэд:

- Хуулийн этгээдийн зардал 318,400 төгрөг
- Төрийн байгууллагын зардал 3,292,625 төгрөг

Нийт 3611025 төгрөгний зардал гарах тооцоо гарч байна.

---oOo---

## ГААЛИЙН АЛБАН ТАТВАРЫГ ХӨНГӨЛЖ, БУЦААН ОЛГОХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын гаргаж байгаа зардлыг тооцож, цаашид ачааллыг багасгах санал боловсруулахад энэхүү судалгааны зорилго оршино.

### 1. Хуулийн этгээдийн зардал

Энэхүү хууль нь Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт баригдах газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын хотхоны барилга байгууламжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй, импортоор оруулж ирэх бараа материалд тухайн татварын жилд ногдуулан төлсөн гаалийн албан татварыг 100 хувь хөнгөлж дараа жилийн эхний улиралд багтаан буцаан олгуулахад хамааралтай ба хуулийн этгээдийн хувьд хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гарах мөнгөн зардлыг тооцов.

Бараа материал импортлогч хуулийн этгээдийн хувьд нэгж бүрийн гаалийн бүрдүүлэлт хийх хугацаа нь дунджаар 480 минут байдаг бол гаалийн албан татварын хөнгөлөлт эдэлснээр бүрдүүлэлт хийх хугацаа 120 минут болж нэгж бүрийн бүрдүүлэлт хийх хугацаа даруй 2 дахин буурах боломжтой юм.

<i>Хуулийн төслийн 1,2 дугаар зүйлтэй холбоотой хуулийн этгээдээс гарах зардал</i>	
<i>Гүйцэтгэх ажил, үйлчилгээ</i>	<i>Хэмжих нэгж</i>
Энэхүү хуультай танилцах, судлах	15 минут
Шинэ хуулийн мэдээлэл цуглуулах	15 минут
Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх	10 минут
Тооцоо хийх, нягтлах	120 минут
Олшруулах, архивлах	15 минут
Дотоод хуралдаан	60 минут
Шилжүүлэг хийх	30 минут
Нэмж мэдээлэл цуглуулах	30 минут
<b>Нийт</b>	<b>295 минут</b>
Уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын сарын дундаж цалин	1088.2 мян.төгрөг
Уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын минутын дундаж цалин	108 төгрөг
Ажлын хөлс	31840 төгрөг
Хамрагдагчдын тоо	10
Тоон үзүүлэлт	1
Давтамж	Байхгүй
<b>Нийт зардал</b>	<b>318400 төгрөг</b>

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Энэхүү хууль хэрэгжсэнээр хуулийн этгээдэд ачаалал бага гарах ба үүсэх нийт зардал 318400 төгрөг байна.

2. Төрийн байгууллагын зардал

<i>Хуулийн төслийн 1,2 дугаар зүйлтэй холбоотой Төрийн байгууллагаас гарах зардал</i>			
<i>Төрийн байгууллагууд</i>	<i>Гүйцэтгэх ажил, үйлчилгээ</i>	<i>Хэмжих нэгж</i>	
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Хуулийн төсөлд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийн саналыг авч Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдаас санал авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлнэ.	Мэдээлэл цуглуулах	2400 минут /ажлын 5 өдөр/
		Судалгаа, тооцоо хийх	1440 минут /ажлын 3 өдөр/
		Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулах	480 минут /ажлын 1 өдөр/
		Албан бичиг боловсруулах	20 минут
		Бичиг баримт олшруулах	15 минут
		Бичиг тараах, бүртгэх	60 минут
		Дотоод хуралдаан	60 минут
Гаалийн ерөнхий газар	“Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-ийн тухай олон улсын конвенцийн дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас ирүүлсэн гаалийн албан татвараас чөлөөлүүлэх технологийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл болон тусгай зориулалтын барилгын материалын шинж чанар, зориулалт, зүйл бүлгээр судлан тодорхойлох.	4800 минут /ажлын 10 өдөр/	
<b>Нийт</b>		<b>9275 минут</b>	
Төрийн албан хаагчийн сарын дундаж цалин		717,100 төгрөг	
Төрийн албан хаагчийн минутын дундаж цалин		71 төгрөг	
Ажлын хөлс		658,525 төгрөг	
Хамрагдагчдын тоо		5	
Тоон үзүүлэлт		1	
Давтамж		Байхгүй	
<b>Нийт зардал</b>		<b>3,292,625</b>	

	төгрөг
--	--------

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, Гаалийн ерөнхий газар

Хууль батлагдсанаар Төрийн байгууллагаас зарцуулах хугацаа буюу ачаалал 9275 минут байх бөгөөд түүнтэй холбогдон гарах зардал нь 3,292,625 төгрөг байна.

### Дүгнэлт

Гаалийн албан татварыг хөнгөлж, буцаан олгох тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах зардлын тооцоог батлагдсан аргачлалын дагуу хийхэд:

- Хуулийн этгээдийн зардал 318,400 төгрөг
- Төрийн байгууллагын зардал 3,292,625 төгрөг

Нийт 3611025 төгрөгний зардал гарах тооцоо гарч байна.

---oOo---